

## **Байгууллагын алсын хараа**

Ёс зүйг эрхэмлэсэн, стандартад нийцсэн чанартай цогц үйлчилгээг үзүүлэгч иргэдэд эрүүл амьдрах хэвшлийг бий болгогч анхан шатны эрүүл мэндийн төв байна.

## **Эрхэм зорилго**

Үйлчлүүлэгчдэд ээлтэй, чанартай, тасралтгүй, тэгш хүртээмжтэй эрүүл мэндийн шатлалын тусламж үйлчилгээг үзүүлэн, хүн амын нийгмийн эрүүл мэндийг сайжруулж, өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино.

## **Түүхэн замнал**

Сайнцагаан сумын ЭМТ нь анх 1937 онд эмнэлгийн анхны санитарч Ш.Цэдэвсүрэн хүн амд анхны тусламжийг үзүүлж эхэлсэн.1979 онд өөрийн гэсэн байртай болж 1992 онд Сайнцагаан сумын засаг даргын тамгын газрын харьяанд очсон.2010 онд Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийн салбар хөгжил 3” төслийн санхүүжилтээр урд корпус баригдаж, 2016 онд ОНХС-ээр хойд талын 2 давхар өргөтгөлийн хэсэг баригдсан.

Манай эмнэлэг нь 1968, 1980 онд 100 хувьтан, 1985, 1986, 1987, 1989 онд гэмт хэрэг хэв журмын зөрчилгүй байгууллага, 2011, 2012 онд мянганы хөгжил хэрэгжүүлэх хүүхдийн эндэгдэлгүй хамт олон 2008, 2011, 2013, 2015, 2023 онуудад магадлан итгэмжлэлд орж 3-5 жилээр зөвшөөрлийн гэрчилгээ авч 2015 онд сумын “ТЭРГҮҮНИЙ ХАМТ ОЛОН”, 2016 онд шилдэг байгууллагаар шалгаран ажиллаж байгаа хамт олон.

## **Үйлчлэх хүрээ**

Сайнцагаан сумын эрүүл мэндийн төв нь Сайнцагаан сумын 1,2,3,4,7 багийн 2342 өрхийн 7822 иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг.Хамгийн холдоо 75 км радиус бүхий газрын байршилд хүрч үйлчилдэг.

## **Хүний нөөцийн хангалтын байдал**

Ажилчдын тоо 15

Их эмч- 4

Сувилагч-2

Статистикч- 1

Лаборант-1

Эх баоигч бага эмч- 1

Бусад ажилчид-8

Хүний нөөц хангалтын хувь- 75%

**Холбоо барих**

Хаяг: Сайнцагаан, 7-р баг, Нарлаг, худалдааны 1, 103 тоот

Утас: 70593930

Имэйл: [Saintsagaanemt@gmail.com](mailto:Saintsagaanemt@gmail.com)

**Фэйсбүүк:** Дундговь аймгийн Сайнцагаан сумын эрүүл мэндийн төв